

**БАТЛАВ**  
**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН**  
**ДАРГА** *Ч.ГАНБОЛД*  
**2025 оны 03 дугаар сарын 03** өдөр  
*Ч.ГАНБОЛД*

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН АВЛИГЫН ЭСРЭГ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Төсөв	Хугацаа	Хариуцсан болон хамтран хэрэгжүүлэх байгууллага
1	2	3	4	5	6	7
Зорилт 1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлнэ.						
1.1. Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэх;	Түгээсэн мэдээлэл, иргэдийн хандалтын тоо, Харьяа, газар нэгжийг хамруулсан тоо	Хандалтын тоо 65.000 иргэн “АЭҮА-ны тайлан-2024”	66.000 иргэнээс доошгүй	-	1-3 дугаар улирал	Хууль, эрх зүйн хэлтэс
1.2. Байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах;	Нэлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан тоо	4 ажил, арга хэмжээ зохион байгуулсан “АЭҮА-ны тайлан- 2024	Нэлөөллийн 5 ажил арга хэмжээ зохион байгуулна.	2.0 сая	1-3 дугаар улирал	Хууль, эрх зүйн хэлтэс

	Орон нутгийн хэвлэлд сурталчилсан мэдээллийн тоо	-	2 доошгүй хэвлэл мэдээлэлд нийтэлж сурталчилсан байна.	-	1-3 дугаар улирал	Төрийн захиргаа удирдлагын хэлтэс Хууль, эрх зүйн хэлтэс
1.3. Байгууллагын үйл ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий 2-oos доошгүй видео контент бүтээж, олон нийтэд хүргэх;	Боловсруулсан материал, бэлтгэсэн нийтлэл нэвтрүүлгийн тоо	1000 ш тараах материал	2 доошгүй сурталчилгааны материал боловсруулах, 2 доошгүй нэвтрүүлэг, контент бэлтгэн цацах	3,0	2,3 дугаар улирал	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс Хууль, эрх зүйн хэлтэс
Зорилт 2. Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулна.						
2.1. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд Авлигатай тэмцэх газар болон иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх;	Хамтран ажилласан байгууллага, арга хэмжээний тоо	-	2 доошгүй арга хэмжээ зохион байгуулна.	-	1-3 дугаар улирал	Төрийн захиргаа удирдлагын хэлтэс Хууль, эрх зүйн хэлтэс
2.2. Төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах;	Ил тод байршуулж мэдээлсэн мэдээллийн тоо	-	Зохих мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.	-	1-4 дүгээр улирал	Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс
2.3. Байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх;	Дүн шинжилгээ хийсэн мэдээлэл	-	Гомдол мэдээлэл буурсан байна	-	1-4 дүгээр улирал	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
2.4. Сумдын залуучуудад авлигын эсрэг сургалт нөлөөллийн арга	Нөлөөллийн үйл ажиллагаанд					Хууль, эрх зүйн хэлтэс, Соёл ураг,

хэмжээ зохион байгуулж, хууль тогтоомжуудыг таниулах	хамрагдсан сум, запуучуудын тоо	4 сум, 200 залуу	5 сум, 250 залуу	10,000,00	I-IV улиралд	аялал жуучлал, залуучуудын газар
Зорилт 3. Авлига, ашиг сонирхлын зэрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авна.						
3.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр тухайн байгууллагаас цахимаар иргэд, олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулах;	Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо	-	Цахим үйлчилгээний тоог нэмэгдүүлэх	-	1-4 дүгээр улирал	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Хууль, эрх зүйн хэлтэс
3.2.Байгууллагын дотоод хяналтын механизмыг сайжруулж, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх;	Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо	-	Байгууллагын ШБҮнэлгээ сайжирсан байна.	-	2,3 дугаар улирал	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, ,Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтэс, Хууль, эрх зүйн хэлтэс
3.3.Байгууллагын шударга байдлыг үнэлгээг ахиулж, иргэдэд үйлчилж буй үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах;	Хэлтсүүдийн иргэдэд үзүүлсэн үйлчилгээ	74,2% “АТГ- 2024”	74,2 %-иас ахиулах	-	1-4 дүгээр улирал	Тамгын газрын бодлогын хэлтсүүд, сүм, агентлаг
3.4.Сум, агентлаг, төсөвт байгууллагын удирдах тушаалтнуудад АТГ-тай хамтран урьдчилан сэргийлэх сургалт, уулзалтыг зохион байгуулах	Сургалт, арга хэмжээнд оролцсон алба хаагчдын тоо	240 албан тушаалтан хамрагдсан “Эх сурвалж” ХЭЗХ	250 дээш албан тушаалтан хамрагдсан байна.	16.0 сая	1-4 дүгээр улирал	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Хууль, эрх зүйн хэлтэс

-оО-